



ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.ЭНХДЭЛГЭР ТАНАА

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.15 № 01/19 ДУА-2017/21/СТА-ТЦЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад төсвийн нэмэлт орлого **1,800,000.00 /Нэг сая найман зуун мянган/** төгрөгөөр гадаад аялал зохион байгуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46.4-д /Энэ хуулийн 46.3.2, 46.3.3-т заасан урамшууллыг хуваарилах асуудлыг байгууллагын нийт ажилтныг оролцуулсан хамт олны хурлаар хэлэлцэн, шийдвэрлэх бөгөөд хамт олны хурлын тэмдэглэл болон шийдвэрийг үндэслэн тухайн шатны төрийн сан зарцуулах эрх олгоно/, мөн Засгийн газрын 2014 оны “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 147 дугаар тогтоолын 6-д /Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Засгийн газрын 2015 оны 147 дугаар тогтоол болон Улсын Их Хурлын 47 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах;


0000000046

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Засаг даргын тамгын газрын дарга /Г.Энхдэлгэр /, нягтлан бодогч /А.Соёл-Эрдэнэ/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ
ДАРГА



ЗӨВШӨӨРСӨН:

Эрдэнэдалай сумын Засаг даргын
тамгын газрын :
 Г.ЭНХДЭЛГЭР
НЯГТЛАН БОДОГЧ  А.СОЁЛ-ЭРДЭНЭ



ЗПА0001 9033128

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.